

САЙХАН МЭДЭЭ

“РИО 2016” ОЛИМПИЙН МЕДАЛИЙН
БУУХИАГ Д.ОТГОНДАЛАЙ
ҮРГЭЛЖЛҮҮЛЭЭ

II нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

СЭТГЭЛ ГОНСОЙЛГОСОН
ТОМИЛГОО ҮРГЭЛЖИЛСЭЭР...

V нүүрт

ЭРДЭМТНИЙ ЯР



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Дугаарын **60** мөр

ЗАСГИЙН ГАЗАР

Emart нэг л
биш ээ

Х.НОРЖИН

Ж.ЭРДЭНЭБАТ: ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ЦАЛИНГ БУУРУУЛЖ, ОРОН ТООГ ХАДГАЛНА

ЖОТГОН

Солонгосын сүлжээ бүхий дэлгүүр Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо нээгдээд хагас сар болох гэж байна. Монголчуудын сонинч, бие биеэсээ дутахгүй гэдэг этгээд араншин Emart руу хөтөлсөөр. Нээлтээ хийсэн эхний өдрүүдэд өдөрт 348 мянган ам.доллар Солонгос руу урсан гэх мэдээлэл бий. Өнөөдөр ч ялгаагүй солонгос эзний данс руу 300 мянга биш юм аа гэхэд 50-60 мянган ам. доллар шилжиж л байгаа. Эдийн засгийн хямрал хэмээн цалин, тэтгэвэр тэтгэмжээ тавьж чадахгүй баларч суугаа нйм цаг үед мөнгөний урсгал гадагшаа чиглэнэ гэдэг сайны ёр явч биш. Тэр их мөнгө дотоодын зах зээлд эргэлдэн, үндэсний үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн тийм хэмжээнд борлогдож байдаг бол мөн ч сайхан аа. Бид тэгж чадахгүй, иргэдийн санаа сэтгэл, худалдан авах чадварыг солонгос эр шинг татаж чадахгүй юм хойно халаасаа шавхаад л Emart руу харайлгаад байхаас яах вэ.

Үргэлжлэл нь III нүүрт

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат, Сангийн сайд Б.Чойжилсүрэн нар төсвийн асуудлаар мэдээлэл хийлээ. Мэдээллийн эхэнд Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат эдийн засгийн нөхцөл байдал болон Засгийн газраас нэн яаралтай авч хэрэгжүүлэх ажлын талаар товч танилцууллаа. Тэрбээр өнгөрсөн долоо хоногт Сангийн сайд Б.Чойжилсүрэнгийн эдийн засаг, төсөв санхүүгийн асуудлаар хийсэн мэдээллийн дараа багагүй маргаан гарсныг онцлоод үүнтэй холбогдуулж иргэд, хэвлэл мэдээлэл, гадаад дотоодын санхүүгийн зах зээлд бодит мэдээлэл өгөхөөр шийдсэн гэдгээ дуулгав. Тэрбээр “Статистик, эдийн засгийн тоон мэдээллийг буруу тодорхойлж, засвар оруулж мэдээлэл цаашид засч болохгүй нөхцөл байдлыг

бий болгоно. Бид эдийн засгийнхаа оношийг зөв тодорхойлж байж дараа дараагийн авах арга хэмжээ бодлогоо төлөвлөнө. Гэвч харамсалтай нь өдөр бүр Сангийн яаманд бүртгэл тооцоо судалгаагүй арга хэмжээ, концессийн гэрээ, төслүүд ар араасаа гарч ирж байна. Улс орон бүр нэг л төсөвтэй байх ёстой гэсэн дэлхий нийтийн жишгээс хазайх эрх байхгүй. Тийм учраас бодит нөхцөл байдалд энэ олон төсвүүдээ нэгтгэх үйл ажиллагаанд цаг хугацаа их шаардлаа” гэв. Өөрөөр хэлбэл, төсвийн бодлогыг сайжруулах хүрээнд бүх төсвийг нэгтгэх ажлыг Засгийн газраас хийж эхлээд байгаа аж. Ерөнхий сайдын хэлж буйгаар төсвийн тодотгол хийхгүй бол оны төгсгөлд төсвийн алдагдал нь ДНБ-ий 21.6 хувь дээр ирэх төлөв ажиглагдаж байгаа юм байна.

Үргэлжлэл нь III нүүрт

С.НАСАН-УРТ: ХЭЛ, СОЁЛЫНХОО АЛТАН ЦУЛБУУРЫГ ЧАНГААТГАСАН УЛС ТОГТВОРТОЙ ХӨГЖДӨГ

Дэлгэрэнгүй ярилцлагыг IV нүүрнээс

ИЛҮҮ ИХИЙГ БҮТЭЭХ ХҮЧ
Онцгой урамшуулал

ХУДАЛДАН АВАЛТ БҮРТ emart
ДЭЛГҮҮРЭЭР ҮЙЛЧЛҮҮЛЭХ 50,000₮-ний
ваучер бэлэглэнэ.

Цүнх + 2 жилийн баталгаа + McAfee SECURE Вирусын програм

Ваучерийн тоо хязгаартай

ӨЛЗИЙ БИЛЭГТЭЙ
БАГЦЫН ХЯМРАЛТАЙ

2-3 СОНГОСОН БАРААГАА
БАГЦЫН ХЯМРАЛТАЙ ҮНЭЭР АВААЦ

40%
ХЯМДРУУЛАН АВААРАЙ

ХААН банк	Хуудалгаа хөгжлийн банк			
	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2195.00	2223.00	ФУНТ	2795.00
ЕВРО	2429.00	2546.00	РУБЛЬ	21.49
ИЕН	21.49	22.57	ЮАНЬ	329.70



САЙХАН МЭДЭЭ



РИО 2016

“РИО 2016” ОЛИМПТИЙН МЕДАЛИЙН БУУХИАГ Д.ОТГОНДАЛАЙ ҮРГЭЛЖЛҮҮЛЭЭ

Ж.МЯГМАР

“Рио 2016” олимпын наадм амжилттай үргэлжилж байна. Монгол Улсын баг тамирчдаас Рио-2016 олимпын хоёр дахь медальтан болсон Д.Отгондалай өчигдөр өглөө хүрэл медалийн өнгөө хувиргах шийдвэрлэх тулаанаа хийсэн. Манай тамирчин гурван үеийн турш өрсөлдөгчөө давамгайлсан боловч шүүгчид Францын тамирчинд ялалт өгснөөр тэрбээр хүрэл медаль дээр буусан.

Тэрбээр тоглолтын дараа сэтгүүлчид өгсөн ярилцлагадаа “Би сая эхний хоёр раундад өөрийгөө хожиж байгаа гэдэгт бүрэн итгэлтэй байсан. Өөрөө дөвжээн дээр байгаа хүн эхэдэн цохилт оновчтой болж байна гэдгийг тооцоолно. Ерөнхий тоглолтын байдлыг мэдэртнэ. Нэг дэх үед би гарцаа байхгүй 3:0-ээр хожсон гэж бодож байлаа. Хоёр дээр ч оноо илүү байх ёстой гэж бодсон. Гуравдугаар раунд дээр харин оноо доогуур байна гэхээр нь урагшаа нэлээд дайрч, хайхрамж алдсан тал бий. Маш харамсалтай байна. Эхний хоёр раунд монголчууд бидний ялалт байсан” хэмээсэн юм. Гэвч монгол түмэн түүнийг хайрлаж, урмын үгээр хүч нэмсээр байгаа билээ.

Ингээд Монголын багийн хоёр дахь медалийн эзэнээр тодорсон ОУХМ Д.Отгондалайн талаархи зарим баримтыг хүргэе. Тэрбээр 1988 оны нэгдүгээр сарын 28-нд Дорнод аймгийн Чойбалсан хотод мэндэлсэн бөгөөд олимпын наадамд анх удаагаа



photo by Ch. Ganbat

оролцож байгаа юм.

15 настай байхдаа буюу 2003 онд ангийнхаа долоон хүүхдийн хамт МУГД Ё.Төмөрбатаагийн боксын секцэд элсч байсан гэдэг. Энэ тухайгаа тэрбээр гэрийнхнээсээ нууцалж байсан ч сарын 1500 төгрөгийн төлбөрөө олохын тулд аргагүйн эрхэнд ээждээ хэлснээр нууц нь задарчээ.

Ээж нь хүүдээ санаа зовниж, секцийнх нь багш Ё.Төмөрбатаатай уулзахад “Хүүг чинь би шалгаж үзлээ. Их авьяаслаг хүүхэд байна. Өөрөө ч их сонирхолтой байгаа учраас та хичээллүүлээд үз” гэж хэлснээр

санаа нь амарч тайвширсан гэдэг. Ингээд Д.Отгондалай тэр жилдээ “Олимпын гараа” хэмээх хүүхдийн боксын тэмцээнд амжилттай оролцож, амжилтын гараагаа эхлүүлж байжээ. Залуусын нэрлэдгээр Оки 2005 онд Залуучуудын УАШТ-ий амжилтаараа Боксын шигшээ багт элссэн цагаасаа хойш өнөөг хүртэл 60 кг-ын жинд тоглож байгаа. Олон жил жингээ барих, жин хэлбэлзсэн үед хасч, нэмж тохируулна гэдэг тамирчин хүнээс асар их хөдөлмөр шаарддаг. Энэ жиндээ Монголд төдийгүй тивдээ тэргүүлж буй тэрээр цаашид ч

мөн 60 кг-ын жингээрээ тоглох бодолтой явдаг гэдгээ ч тэрбээр илэрхийлсэн байдаг.

Д.Отгондалай Гадаад худалдаа болон Гаалийн удирдлага гэсэн мэргэжлээр “Зохиомж” дээд сургуулийг төгссөн. Гэхдээ 2008 оноос Хил хамгаалах ерөнхий газрын дэргэдэх “Хилчин” спорт хороо, Хилийн 0168 дугаар ангид ажиллаж болсон. Дэслэгч цолтой. Харин спортын замналаа өндөрлүүлж, зодог тайлсныхаа дараа Дорнод нутагтаа хил хамгаалах албанд ажиллах хүсэлтэй байдаг билээ. Тэрбээр 2014 онд БНСУ-ын Инчён хотноо зохиогдсон Азийн

наадмын Алтан медаль, 2015 онд Азийн аварга шалгаруулах тэмцээний Алтан медаль, 2016 онд Олимпын эрх олгох тэмцээнээс Алтан медаль тус тус хүртэж байсан билээ.

Д.Отгондалай “Рио-2016” олимпын наадмын эрх олгох Ази, Номхон далайн бүсийн боксын тэмцээний хагас шигшээ тоглолтод Японы Д.Наримацуг 3:0-ээр ялж, мөнгөн медалийн болзлыг биелүүлснээр Олимпын эрхээ өвөртөлсөн бөгөөд өнөөдөр олимпын медалийг энгэртээ зүүж, төрийнхөө далбааг Риогийн тэнгэрт мандууллаа.

Эрээн хоттой боловсролын салбарт хамтран ажиллана

НИТХ-ын дарга Ц.Сандуй БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хотын Намын хорооны байнгын гишүүн, Хотын байнгын орлогч дарга Уулыг хүлээн авч уулзлаа. Уулзалтаар Улаанбаатар, Эрээн хотуудын хамтын ажиллагааны талаар санал солилцов. Эрээн хотын Намын хорооны байнгын гишүүн, Хотын байнгын орлогч дарга Уул “Эрээн хотод болох долоо дахь удаагийн Хятад, Монгол, Орос улсын эдийн засгийн чуулга уулзалтад оролцохыг урьж байна. Энэхүү чуулга уулзалт нь Хятад, Монгол, Оросын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны чухал гүүр холбоос болж, олон улсад нөлөөлөх хүч нь тасралгүй дэвшилсээр байна. Монгол Улс идэвхтэй оролцож байгаад баяртай байна” гэлээ. Мөн тэрбээр Эрээн, Улаанбаатар хоттой боловсролын салбарт түлхүү хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийллээ. Харин Нийслэлийн ИТХ-ын дарга Ц.Сандуй “Улаанбаатар, Эрээн хотуудын эртний найрсаг харилцаа үргэлжилж байгаад талархалтай байна. Цаашид ч хоёр хотын хамтын ажиллагаа өргөжин хөгжих болно. Эрээн хотын “Хятад, Монгол, Оросын эдийн засаг худалдааны хамтын ажиллагааны чуулга уулзалт нь олон талын ач холбогдол бүхий олон улсын чуулга уулзалт болж чадсанд баяртай байгаагаа илэрхийлэе. Нийслэл, Эрээн хоттой боловсролын салбарт хамтран ажиллах боломжтой. Боловсролын яам, салбар хариуцсан хүмүүстэй зөвшилцөж, ямар байдлаар хамтран ажиллахаа тодорхой болгох хэрэгтэй” гэв.

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158**

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ 88873012**

Ахлах редактор: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: **Н.ПУНЦАГБОЛД 88096454**

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТОГТОХ 88006842**

Гэрэл зургийн алба: **Г.АРГУУЖИН 96017873**

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ 99998796**

Маркетинг, зар сурталчлаланы алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710**

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ 99042510**

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн **Э.ЭНХЦЭЦЭГ**

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: **Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот**

Харилцах утас, факс: **976-70113551**

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Ази, Номхон далайн орнуудын Иргэний нисэхийн дарга нар Монголд чуулна

Олон улсын Иргэний нисэхийн байгууллага /ИКАО/-ын Ази-Номхон далайн бүсийн орнуудын Иргэний нисэхийн Ерөнхий захирлуудын 53 дугаар хурал Бүгд Найрамдах Ардчилсан Социалист Шри Ланка Улсын Коломбо хотноо өнгөрсөн долоо хоногт амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тус хуралд Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Г.Нямдаваа тэргүүтэй бүрэлдэхүүн оролцоод ирлээ. Жил бүр зохион байгуулагддаг уг хуралд ИКАО-ын гишүүн, Ази-Номхон далайн бүсийн 51 орны иргэний нисэхийн удирдах байгууллагын дарга, удирдлагууд оролцсон байна. Тухайлбал, Олон Улсын Иргэний нисэхийн байгууллагын зөвлөлийн ерөнхийлөгч доктор Олумуива Бернард, Бүсийн захирал ноён Арун Мишра, Шри Ланка Улсын Нисэхийн удирдах байгууллагын дарга ноён Нималсири, Бүс нутгийн Ерөнхий захирлууд, олон улсын байгууллагуудын зочин төлөөлөгчид оролцжээ. Дээрх хурлаар өнгөрсөн онд зохион байгуулагдсан 52 дугаар хурлаас хойш ИКАО-аас авч хэрэгжүүлсэн болон цаашид хэрэгжүүлэх бодлого чиглэл, арга хэмжээ, бүс нутгийн хэмжээнд тулгарч буй шийдвэрлэх асуудлууд, шинэ техник, технологи танилцуулах, ирэх жил Улаанбаатар хотноо зохион байгуулагдах 54 дүгээр хурлын бэлтгэл ажил, хурлын

тов тогтоох зэрэг олон асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна. Хурлын нээлтийн үйл ажиллагаанд ИНЕГ-ын дарга Г.Нямдаваа оролцож үг хэлсэн. Тэрбээр, энэ удаагийн хурлын Дэд даргаар сонгогдож, итгэл хүлээлгээнд нь талархал илэрхийлээд хурлын үйл ажиллагааг удирдан явуулахад гар бие оролцон үйл ажиллагаа амжилттай явуулахад бүхий л хүч чармайлтаа гарган ажиллах болно гэдгээ хэлжээ. Түүнчлэн “Олон улсын байдал ээдрээтэй, харилцан ойлголцол, эв нэгдэл, хамтын ажиллагаа нэн чухал байгаа өнөөдөр, “Аюулгүй, найдвартай, байгаль орчинд ээлтэй нисэхийн тогтолцоог нийтээрээ дэмжин хөгжүүлэх нь” сэдвээр хэлэлцэх нь бүс нутгийн хувьд нэн чухал юм” гэжээ. Коломбо хотноо болсон хуралд манай улсын хувьд өндөр ач холбогдол өгч оролцсон. Учир нь 2017 онд 54 дэх хурлыг Улаанбаатар хотноо зохион байгуулах эрхийн билэгдэл бүхий тугийг энэ хурлын үеэр албан ёсоор хүлээж авлаа. Улаанбаатар хотод ирэх оны наймдугаар сарын 7-11-ний өдрүүдэд Ази-Номхон далайн бүсийн орнуудын Иргэний нисэхийн байгууллагын Ерөнхий захирлуудын 54 дүгээр хурлыг удирдан зохион байгуулахаар төлөвлөж буй. Тиймээс энэ удаагийн хуралд агаарын навигацийн чиглэлээр дөрвөн мэдээлэл, хурал зохион байгуулахтай холбоотой

нэг хэлэлцүүлэг бэлтгэн оролцсон. Түүнчлэн ирэх жилийн хурлыг “Ази, Номхон далайн бүсийн орнуудын эрсдэлд тулгуурласан, үр дүнд чиглэсэн зохицуулалтад тулгамдаж буй асуудлууд” сэдвийн дор зохион байгуулахаар батлуулжээ. Хурлын хаалтын үйл ажиллагаанд Нислэгийн хөдөлгөөн удирдах газрын дарга П.Ганболд үг хэлсэн байна. Тэрбээр “Энэхүү хурлыг амжилттай зохион байгуулж тулгамдсан асуудлуудыг шийдэх гаргалгааг тодорхойлж, хөгжлийн их замд бас нэгэн шинэ алхмыг хийхэд түүхэн үүрэг гүйцэтгэсэн Шри Ланка Улсын Иргэний нисэхийн захиргаанд талархалаа илэрхийлэе. Манай санаачлагыг дэмжин ээлжит 54 дүгээр хурлыг 2017 онд Монгол Улсад зохион байгуулах шийдвэр гаргасан ИКАО, АНДБ-ийн төв, хурлын хүндэт төлөөлөгч та бүхэнд талархал дэвшүүлэе. Монгол Улсын Иргэний нисэхийн ерөнхий газар ирэх хурлыг эх орондоо хүлээн авч, бүс нутгийн нисэхийн үсрэнгүй хөгжил, техник технологийн дэвшилд дорвитой хувь нэмрээ оруулах болно гэдгээ илэрхийлж байна. Өнө эртний түүхтэй, үндэсний өвөрмөц уламжлал соёлтой, байгалийн гайхамшигт цогцолбор болсон хөх тэнгэрийн орон Монголд та бүхэнтэй нэг жилийн дараа эргэн уулзах өрөөл дэвшүүлэе. Манай сайхан оронд тавтай морилорой” гэжээ.

Монгол судлаач эрдэмтдийг Төрийн дээд цол, олон, медалиар шагнав

Монгол Улсыг олон улсад таниулах, Монгол судлалыг гадаад, дотоодод хөгжүүлэн дэлгэрүүлэх үйлсэд оруулсан хичээл зүтгэл, хувь нэмрийг нь өндрөөр үнэлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар гадаад, дотоодын зарим эрдэмтэн, судлаачдыг Төрийн дээд цол, олон, медалиар шагнав. Шагналыг Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж өчигдөр гардуулан өглөө. Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цолоор Монгол Улсыг олон улсад таниулах, Монгол судлалыг гадаад, дотоодод хөгжүүлэх, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд хагас зууны туршид ажил амьдралаа зориулан хөдөлмөрлөж ирсэн хичээл зүтгэлийг нь өндрөөр үнэлж, МУИС-ийн зөвлөх багш, доктор, профессор Г.Цэрэнханд, Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор, профессор Ж.Цолоо нарыг шагнав. Түүнчлэн Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор ШУА-ын хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Р.Отгонбаатарыг,

Алтангадас одонгоор ОХУ-ын иргэн, Олон улсын Монгол судлалын холбооны гишүүн, монголч эрдэмтэн Бойкова Елена, СУИС-ийн сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал Чулууны Алтанцэцэг, Япон улсын иргэн, Олон улсын Монгол судлалын холбооны гишүүн, монголч эрдэмтэн Хироки Ока, МУИС-ийн Монгол хэл шинжлэлийн тэнхимийн эрхлэгч М.Баярсайхан нарыг шөгнөж урамшууллаа. Харин Найрамдал медалиар ХБНГУ-ын иргэн, Олон улсын Монгол судлалын холбооны гишүүн, монголч эрдэмтэн Ута Шёне, Олон улсын Монгол судлалын холбооны гишүүн, монголч эрдэмтэн Родика Поп, ХБНГУ-ын иргэн, Олон улсын Монгол судлалын холбооны гишүүн, монголч эрдэмтэн Инес Шгольце, ОХУ-ын иргэн, Эрмитаж улсын музейн Дорно дахины салбарын ажилтан Крамаровский Марк Григорьевич, БНХАУ-ын ӨМӨЗО-ны иргэн, Өвөр Монголын их сургуулийн багш Сэйнгойровын Насан-Урт нарыг тус тус шагналаа. Шагнал гардуулсны дараа Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж хэлсэн үгэндээ “Олон

улсын монголч эрдэмтний 11 дүгээр их хурал нээлтээ хийж буй энэ өдөр монгол судлалын салбарт амжилт бүтээлээрээ тэргүүлж байгаа дотоод гадаадын шилдэг эрдэмтдэд Есөн хөлт цагаан тугийн цэнгэн орших хүндэтгэлийн өргөөнд Төрийн дээд цол, олон, медаль гардууллаа. Монгол үндэстний хэл соёл, түүх, сэтгэлзэний онцлог, Монгол Улсын нийгэм, эдийн засаг, гадаад харилцааны салбарыг шинжлэх ухаанд үндэстэй судлан тайлбарлах үйлсэд нөр хичээнгүй зүтгэл гарган ажиллаж байгаа судлаач та бүхэнд баярлалаа. Энэ шагнал бол Монголыг судалж, шинжлэх ухаанд үнэтэй хувь нэмэр оруулсныг тань үнэлж буй Монгол төрийн хүндэтгэл юм. Мөн таны багш, шавь, хамтран зүтгэгчдэд тань олгож байгаа урам юм. Монголын төр, судлаачид хамтран монгол судлалыг хөгжүүлэхийн төлөө улам бүр хичээнгүйлэн ажиллана. Өнөөдөр хөдөлмөр, зүтгэлээ үнэлүүлсэн та бүхэнд эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн өрөөсөн. Монгол төрийн сүлд өнөд биднийг ивээх болтугай. Баяр хүргэе” гэлээ.

“Хүндэт гэрчилгээ”-тэй Т.Аюурсайхан гишүүн хэрэглэгчдийн эрхийг хамгаалах гэнэ

ШӨХТГ-ын даргаар О.Магнай ажиллаж байгаад Т.Аюурсайханд ажлаа хүлээлгэж өгч байсан цаг саахан. Т.Аюурсайхан дарга ч ажлаа хүлээж авсан даруйдаа нийслэлийн Засаг даргаар ажиллаж байсан Э.Бат-Уултэй нэлээд “тулаад” амжсан. Үүнийхээ хүчинд тэрбээр УИХ-д нэр дэвших эрхтэй болж, түүгээр ч барахгүй олонхийн дэмжлэгийг хүлээж, эдүгээ УИХ-ын гишүүний сэнтийд залраад буй. Тэгвэл Т.Аюурсайхан гишүүний өчигдөр ШӨХТГ-ын дарга Д.Мөнхтөр албан хаагчдын хамт хүлээн авч, хүндэтгэл үзүүллээ. Уулзалтын үеэр ШӨХТГ-ын дарга Д.Мөнхтөр “Манай агентлагаас төр түмнийгээ төлөөлж явах, төр түшицлэх анхны УИХ-ын гишүүн төрж чадлаа” хэмээгээд Т.Аюурсайханд “Хүндэт гэрчилгээ” гардуулаад амжсан. Харин хүндэт гэрчилгээ гардаг авсан ШӨХТГ-ын дарга асан, УИХ-ын гишүүн Т.Аюурсайхан “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хуулийг УИХ-ын намрын чуулганд өргөн барина гэдгээ хамт олныхоо өмнө амлав. Ямартай ч “Хүндэт гэрчилгээ”-тэй Т.Аюурсайхан гишүүн УИХ-ын намрын чуулган эхэлмэгц л “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай” хуулиа өргөн барих гээд тун завгүй байх бололтой.

ҮЗЭЛ БОДОЛ

ЗАСГИЙН ГАЗАР

Ж.ЭРДЭНЭБАТ

...Ямар ч байсан ипотекийн зээлийг зогсоохгүй. Монголбанкн дээр мөнгө хэвлэж эх үүсвэрийг цаашид шийдэх үү, байгаа боломжийн хүрээнд үргэлжлүүлэх үү гэдгийг Засгийн газрын төвшинд шийднэ...



Гэрэл зургийг Г.АРУУЖИН

ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ЦАЛИНГ БУУРУУЛЖ, ОРОН ТООГ ХАДГАЛНА

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Тиймээс УИХ-ын даргад Ээлжит бус чуулганыг хуралдуулж, төсвийн тодотголыг хэлэлцэх хүсэлтийг Ерөнхий сайдаас тавиад байгаа гэнэ. Ийнхүү төсвийн тодотгол хийснээр макро эдийн засгаа тогтворжуулж, төсвийнхөө асуудлыг зөв голдиролд оруулах боломж бүрдэнэ гэж үзэж байгаа юм байна. Төсвийн тодотголтой цуг “Эдийн засгийн хүндрэлээс гарах хөтөлбөр” боловсруулж, өргөн барихаар Засгийн газраас бэлтгэж байгааг Ерөнхий сайд энэ үеэр онцолж байлаа.

Тодруулбал, Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээгээ хоёр үе шатанд хуваажээ. Эхний үе шатанд ойрын хугацаанд буюу 12-18 сарын хугацаанд “Макро эдийн засгаа тогтворжуулах, төсвөө эрүүлжүүлэх”-ээр төлөвлөжээ. Ингэхгүйгээр цаашаа явбал одоогийн алдаагаа давтаж, эдийн засгаа хямралаас гаргах боломжгүй гэж үзэж байгаа аж. Хоёрдугаар үе шатанд макро эдийн засгаа тогтворжуулж, төсвийн төлөвлөлтөө бодит эдийн засгийн хөрсөнд хүргэсний дараа “Эдийн засгаа дэмжсэн бодлого хэрэгжүүлэх” нь зүйтэй гэж үзэж байна. Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат мөн “Маш сайхан зүйл ярьдаг ч огт хийдэггүй” нь манай улсын нэг том хүндрэл. Өнөөдрийн жишээгээр гэхэд Улаанбаатар хотыг тойрсон 5-6 эрчим хүчний төсөл байна. Тэднээс зөвхөн нэгийг нь хэрэгжүүлэхэд л Улаанбаатар хотыг бүхэлд нь хангах эрчим хүч үйлдвэрлэх боллоцоотой. Тиймээс манай Засгийн газар давхардсан олон төслүүдийг хумиж, салбар болгонд улс орны хэрэгцээ шаардлагыг хангахуйц, ард иргэдэд хэрэгцээтэй 1-2 төслийг барьж ажиллана. Үүнийг хэрэгжүүлсний дараа өөр шинэ төсөлд орох ёстой гэж

үзэж байгаа” гэлээ. Мэдээллийн төгсгөлд Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат “Эдийн засгийн нөхцөл байдал нэлээд хүндхэн байгааг хүн бүр мэдэж байгаа. Бид худлаа хэлээд хэрэггүй, өөрсдийгөө хуураад явах шаардлагагүй гэж бодсон. Хэзээ ч бид гадны хөрөнгө оруулагчдыг хуурч чадахгүй. Үнэн бодит байдлаа мэдээлж байж эх үүсвэр босгож авдаг. Аливаа тоон мэдээллийг засч залруулснаар эдийн засагт учрах хохиол нь маш их. Тийм учраас бид эхний ээлжинд тоон мэдээллээ үнэн зөв, бодитгоор гаргаж тавьсан. Цаашдаа үүндээ үндэслэл эдийн засгаа эрүүлжүүлэх эмчилгээ хийнэ” хэмээн юм.

Ийнхүү мэдээлэл хийсний дараа сэтгүүлчдийн асуултад харуулсан юм.

“Стэнд бай” хөтөлбөрт ойрын үед хамрагдах уу?

Олон улсын валютын сан жил бүр улс орнуудын эдийн засагт үнэлэлт дүгнэлт өгдөг. Олон улсын валютын сангийн ажлын хэсэг маргааш Монголд ирнэ. Тэд манай улсын эдийн засагт үнэлэлт дүгнэлт өгөх байх. Бид тэдэнтэй хамтран ажиллана. Өмнө нь бид Дэлхийн банктай хамтран ажиллаж л байсан.

Эрдэнэбат үйлдвэрийг хувьчлах асуудлыг шалгах ажлын хэсэг байгуулагдаж ажилласан. Энэ юу болж байгаа бол?

Ажлын хэсэг гарсан. Одоогоор ажиллаж байгаа. Энэ талаархи мэдээллийг УИХ-ын чуулганы хуралдаанд танилцуулах болно.

Төсвийн тодотголын талаар мэдээлэл өгөөч. Хэзээ өргөн барих вэ?

Төсвийн тодотголыг боловсруулж байгаа. Удахгүй бид өргөн барина. Төсвийн тодотголын хүрээнд шаардлагатай зардлуудыг оруулах, зарим үйл ажиллагааг

хойшлуулах гэх мэтээр ажиллаж байна. Хэрэв төсөв энэ байдлаар үргэлжилбэл төсвийн алдагдал ДНБ-ий 21 хувьтай тэнцэнэ.

Нэг ам.доллар 2200 төгрөгт хүрлээ. Энэ талаар Засгийн газар ямар ажил хийхээр төлөвлөж байгаа вэ?

Хэд хэдэн учир шалтгаан бий. Монголбанкаас авч хэрэгжүүлж байгаа бодлогын хүрээнд тодорхой хэмжээний валютыг зах зээлд нийлүүлж байна. Гэхдээ 2013 онд валют огцом өсч байсан. Тухайн үед “Үнэ тогтворжуулах” хөтөлбөр хэрэгжүүлэхэд гурван их наяд төгрөг хэвлэж гаргасантай холбоотой байдаг. Тэгвэл энэ байдлаас өнөөдөр давтагдаж байна. “Сайн” хөтөлбөрүүд, ипотекийн зээлийн хүрээнд нэг их наяд төгрөг хэвлэж гаргасан. Бид валютын нөөцөө нэмэгдүүлэхийн тулд экспортын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх ёстой. Сүүлийн хэд хоногийн дотор дэлхийн зах зээл дээр нүүрс, алтны үнэ өсөх хандлага ажиглагдаж байна. Энэ нь валютын нөөц нэмэгдүүлэхэд тодорхой хэмжээгээр нөлөөлөх байх. Хоёрдугаарт, гадны хөрөнгө оруулагчдыг татах үүднээс Засгийн газраас дэмжлэг туслахаа үзүүлнэ, тэдний эрх ашгийг хамгаална.

Төсвийн тодотголд төрийн албан хаагчдын цалинг хасахаар тусгаж өгөх үү?

Төрийн албан хаагчдад цалингийн бууралт хийнэ. Засгийн газрын зүгээс иргэдийг аль болох ажилтай байлгахыг хичээнэ. Эдийн засаг хүндэрсэн үед иргэд ажилгүй болох тусам хүнд дарамт үүсдэг. Тиймээс иргэдээ ажилтай байлгаж, тодорхой салбарууд дээр цалин бууруулах арга хэмжээг хийхээс өөр аргагүй байна. Цалингийн төвшин бага төрийн албан хаагчид дээр бууралт хийхгүй гэсэн чиг баримталж байгаа.

Ипотекийн зээлийг үргэлжлүүлэн олгох эсэх асуултад

Засгийн газраас ямар байр суурь илэрхийлэх вэ?

Барилга хот байгуулалтын яаман дээр салбарын сайдаар нь ахлуулсан Ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг ипотекийн зээлийг цаашид ямар хувилбараар олгож болох асуудлыг судалж байна. Иргэдээс ипотекийн зээлд хамрагдах орон сууцны талбайн хэмжээг ихэсгэж өгөх, урьдчилгаа төлбөрийг багасгах, зээлийн хүүг бууруулах асуудлаар санал хүсэлт маш их ирдэг. Энэ бүх асуудлыг бодлогын хүрээнд дахин боловсруулна. Ямар ч байсан ипотекийн зээлийг зогсоохгүй. Монголбанкн дээр мөнгө хэвлэж эх үүсвэрийг цаашид шийдэх үү, байгаа боломжийн хүрээнд үргэлжлүүлэх үү гэдгийг Засгийн газрын төвшинд шийднэ.

Эрх баригч нам “Мэргэжлийн Засгийн газар” байгуулна гэж мөрийн хөтөлбөртөө тусгасан. Гэтэл ачир дэрээ эсрэг томилгоо хийгдлээ гэх хүн цөөнгүй байна. Та танхимын сайд нараа эрхэн дүгнэж байгаа бэ. Мэргэжлийн байж чадаж байгаа юу?

Манай Засгийн газрын баг бүрэлдэхүүн бол сайн менежмент хийх чадвартай баг гэж би харж байгаа. Төрд тодорхой хэмжээнд ажилласан туршлагатай сайн менежмент хийнэ гэдэгт итгэлтэй байна. Хэвлэл мэдээлээр янз бүрийн л мэдээлэл явж байна. Ийм асуудлууд дөр би тайлбар хиймээргүй байна. Ер нь МАН хуулиа дээдлэх замаар л томилгоогоо хийж байгаа.

“Bank of China”-аас Засгийн газар зээл авна гэсэн мэдээлэл цацагдаад байна. Энэ үнэн юм уу?

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад салбараа нээгээд, үйл ажиллагаагаа явуулах хүсэлтэй байгаа гадны дөрвөн банк байгаа. Одоогоор тэр дөрвийн нэрийг хэлэх боломжгүй. Тэдгээрийн

нэг нь “Bank of China” юм. Бид эдгээр банкуудыг судалж байгаа. Судалгаа тооцоогоо сайн хийж байгаад шийдвэрээ гаргана.

Хавтгайрсан халамжуудыг багасна гэлээ. Хүүхдийн мөнгө, оюутны 70 мянган төгрөгийг үргэжлүүлэн олгох уу?

Хүүхдийн мөнгийг төсөвт тусгахдаа зорилготой бүлгүүдэд өгнө гэж тусгасан. Сонгуулийн өмнө хавтгайруулан өгснөөр одоо хүүхдийн мөнгө олгож чадахгүйд хүрээд байна. Төсвийн тодотголын хүрээнд халамжуудыг тодорхой зорилготой бүлгүүдэд өгөх чиглэлийг Засгийн газраас барьж ажиллана.

Жилийн өмнө та Сангийн сайдаар ажиллаж байсан. Сая ярьснаас тань дүгнэвэл таныг Сангийн сайдын албан тушаалаа өгснөө хойш улсын төсөв замбараагүй болсон юм байна гэж ойлголоо. Ер нь таныг Сангийн сайдаар ажиллаж байхад төсөв ямар байдалтай байсан юм бэ?

Намайг Сангийн сайдаар очиход их сайхан байж байгаад бууснаас хойш муухай болсон гэж огт хэлээгүй. Ажил авахад хүнд л байсан. Эдийн засгийн нөхцөл байдал, төсөв санхүүгийн байдал хүндэрсэн байна гэдгийг тухайн үед хэлж байсан. Төсөв хэтрээд, өрийн хэмжээ хэтрэсэн байсан учраас Өрийн удирдлагын тухай хуулийг батлуулсан эдийн засгийн хүндрэлийг давах арга хэмжээний хөтөлбөрийг батлуулж байсан. Өрийнхөө таацыг өөрчилж байсан. Төсвийг эрүүлжүүлэхээр ажиллаж эхэлсэн. Миний үед дөрвөн төсөв Монголд үйл ажиллагаагаа явуулдгийг зогсоож нэгдсэн нэг төсөвтэй болгосон. Олон замбараагүй зүйлийг цэгцэлсэн. Хамтарсан Засгийн газрын үеийн бодлогоо хэрэгжүүлэхэд явсан бол эдийн засаг энэ хэмжээнд хүрчихгүй байсан юм. Бид нэг жилийн хугацааг алдсан байна.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

БСШУСЯ-ныхан долоо хоног бүр иргэдтэй уулзана

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам/БСШУСЯ/-ны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Цэдэвсүрэнгийн тушаалаар тус яамны сайдаас эхлээд газрын дарга, мэргэжилтэнүүд долоо хоног бүр иргэдийг хүлээн

авч уулзах цагийн хуваарь гаргажээ. Үүгээр БСШУС-ын сайд Ж.Батсуурь сар бүрийн хоёр, дөрөв дэх долоо хоногийн мянгар гарагт 14.00-17.00 цагийн хооронд, дэд сайд Ё.Отгонбаяр долоо хоног бүрийн лхагва гарагт 10.00-12.00 цагийн хооронд, тус

яамны Төрийн нарийн бичгийн дарга нь долоо хоног бүрийн пүрэв гарагт 14.00-17.30 цагийн хооронд, газар хэлтсийн дарга болон мэргэжилтэнүүд ажлын өдрүүдэд 10.00-17.00 цагийн хооронд иргэдийг хүлээн авч уулзахаар болсон байна.

Транзит тээврийн туршилтын үйл ажиллагаа эхэллээ

Монгол, Орос, Хятад гурван улсын Эдийн засгийн коридорын анхны ачаа тээврийн пуваа энэ сарын 13-ны өглөө Алтанбулаг боомтоор орж ирлээ. Энэхүү туршилтын тээвэр нь Азийн авто замын сүлжээгээр олон улсын авто тээвэр гүйцэтгэх тухай Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу хийгдэж буй ажлын нэг бөгөөд (Улаан-Үд-Хиагт – Алтанбулаг-Дархан-Улаанбаатар-Сайншанд-Замын Үүд – Эрээн-Бээжингийн гаднах тойрог-Тяньжин) маршрутаар тээвэрлэлт гүйцэтгэх юм. Энэхүү коридор нь 1580 км урт зам туулах тул туршилтын тээвэр нь энэ сарын 13-ны өдрөөс 25-ны өдрүүдэд үргэлжилнэ. Туршилтын транзит тээврийн явцад газар орон, замын нөхцөл байдал, үйлчилгээний газар, автомашинны засвар, бензин шатахуун түгээх газрын байршил зэргийг нэг бүрчлэн тогтоох тул Монгол Улс, ОХУ, БНХАУ гурван улсын авто тээврийн салбарын холбогдох шатны албан тушаалтнууд, Замын цагдаагийн газар, эмнэлгийн анхан шатны тусламж, авто машинд засвар үйлчилгээ үзүүлэх баг зэрэг өргөн бүрэлдэхүүнтэйгээр оролцож байна. Ази, Европ хоорондын чингэлэг тээврийн 90 гаруй хувь нь далайн тээвэрээр, хоёр дахин урт замыг 2-3 дахин их хугацаанд тээвэрлэдэг аж. Зүүн Ази, Европыг холбосон хуурай газрын тээврийн дөрвөн гол замнал байдгаас хамгийн дөт нь Монгол улсаар дайран өнгөрдөг тул эдийн засгийн хэмнэлт бүхий тээвэрлэлт бөгөөд өнөөдрийн байдлаар Ази, Европын хоорондын чингэлэг тээврийн 90 гаруй хувь нь далайн тээвэрээр 45 хоногийн хугацаанд тээвэрлэдгээс цаг хугацаны хувьд алдагдалтай байдаг. Харин Ази, Европ хооронд төмөр замаар ачаа тээвэрлэхэд 10 хоногийн хугацаа зарцуулагддаг бөгөөд авто замаар тээвэрлэлт хийхэд эл хугацааг долоо хоногийн дотор туулах бүрэн боломжтой юм. Зүүн Ази-Европыг холбосон энэхүү ачаа тээврийг хөгжүүлснээр зөвхөн БНХАУ-д экспортлохоос гадна Солонгос, ОХУ, Казахстан улсад ч нийлүүлэх боломж бүрэн бий болох юм.

Дугаарын 60 мөр

Emart нэг л биш ээ

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Гэхдээ бид нэгэнт шавхаж байгаа хэдэн төгрөгөө сайхан орчинд тархиа амраангаа сэтгэлдээ нийцсэн, чанартай бараа бүтээгдэхүүнд өгмөөр байна шүү дээ. Өдөрт дунджаар 1500 орчим хүн Emart –аар үйлчлүүлж байгаа ч тэдний ихэнх нь 30 гаруй минут болоод л гарахын, агаар амьсгалахын түүс болох нь бий. Агааржуулалт дутмагийн гай ийн хамгийн түрүүнд мэдрэгдэнэ. Тэнд бага насны хүүхдээ тэврээд, хөтлөөд явж байгаа гэр бүлийнхэнд зориулан хүүхдээ суулгаад гар амар, сэтгэл тайван үйлчлүүлэх нөхцөл ч алга байна лээ. Тоолоод үзвэл арваас илүү гарахгүй хүүхдэд зориулсан түрдэг тэргийг эцэг эхчүүд булаалдан, ухаан суусан гурван настнууд тэрхүү ногоон өнгийн машин бүхий тэргэн дээр суух гэж орилолдон уйлалдах нь эмгэнэлтэй бас өрөвдмөөр. Үүнээс гадна үйлчлүүлэгчид уг нь солонгос бараа бүтээгдэхүүн худалдаж авах гэж Emart-ыг зорьж очдог байлтай. Гэтэл солонгос шошго бүхий цөөн хэд нь улсынхаа зах зээлээс хэдийнэ шахагдсан, хугацаа нь дуусах шахсан, хийц загвар нь хоцрогдсон бараа бүтээгдэхүүн байх жишээтэй. Бас болоогүй түүнийг өндрөөр үнэлсэн байх юм. Үнэндээ тэндэхийн лангуунуудын ихэнхийг Монголын наймаачдын оруулж ирдэг наймаачдын бараа бүтээгдэхүүн эзэлсэн харагдсан. Ийн супермаркетаас ялгагдах зүйлгүй шахам Солонгосын сүлжээ бүхий Emart дэлгүүр нээлтийн арга хэмжээний дараах долоо хоногос тараа тануулж эхлэв бололтой. Emart бол дундаж амьдралтай солонгосчуудын дэлгүүр гэгддэг. Тэндээ дээр хэлсэнчлэн томоохон үйлдвэрлэгч компанудын зах зээлээс эргүүлэн татсан эсвэл илүүдэл болж үнээ бууруулсан агуулах чөлөөлөх бөөний худалдааны газар ч гэж ойлгож болно. Үүнийг нь Сөүлийн гудамжнаа ширхэг нь 1000 воноор зарагддаг хайруулын таваг, гар нүүрийн алчуур, хамгийн хямдхан шампунь, биеийн шингэн саван, угаалгын нунтаг гэрчилнэ. Монголчууд ч монголчууд. Зах зээлийн үнээс 20 нугалсан үнээр зарагдаж буй барааг нь солонгос бараа чанартай, үнэ нь боломжийн хэмээн авах гэж хөлсөө урсган дугаарлаж зогсогцоохыг нь яана. Өрөвдмөөр ч юм шинг. Монголчууд минь бид чинь ардчиллынхаа буянаар улаан паспортгоо өвөртлөөд хаа сайгүй мордоцгоож, тэр хэрээрээ юм үзэж, нүд тайлцагдсан бус уу. Тиймээс жинхэнэ Emart-ын бараа бүтээгдэхүүн орж ирж худалдаалагдах хүртэл худалдан авалтаа зогсоовол яасан юм бэ.

УЛС ТӨР

ЭРДЭМТНИЙ ЯРИА

Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ

Ийн өгүүлж суугаа эрхэм бол Өвөрмонголын Их сургуулийн багш, хэл шинжлэлийн ухааны доктор, профессор С. Насан-Урт гуай. Түүнийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж буй “Олон улсын монголч эрдэмтний XI их хуралд” оролцож байх үеэр уулзаж ярилцлаа.

-Та бол дэлхийд танигдсан монголч эрдэмтэн. Дэлхийн онцог булан бүрээс ирсэн шавь нар, хамтран зүтгэгчид нь Насаа багш аа хэмээн тохой өргөн амар мэндийг тань эрж байгааг харахад сайхан байлаа. Энд хүрэлцэн ирсэн эрдэмтэн мэргэдийг бүгдийг нь таньж, мэдэж байна уу?

-Юун түрүүнд өвөг дээдсийнхээ өлгий нутагт хүрэлцэн ирж, сэрүүн тунгалаг агаараар нь амьсгалж, хөх тэнгэр дор нь алхалж, эрдэмтэн нөхөдтэйгөө, шавь нартайгаа уулзан учирч, сэтгэлийнхээ үгийг хэлэлцэн, онгөрсөн хугацаанд хэн юу бүтээж, туурвив, хэнээс ямар шинэ санаа оноо гарав гэдгийг чихээрээ дуулж, бие сэтгэлээрээ мэдэрч байгаадаа

бүтээл арвинтай байгаагаа зориуд тэмдэглэн хэлэхийг хүсч байна.

-“...Хэчнээн ч удаа хуралдаж болно. Хамгийн гол нь үр дүн” хэмээн Германаас ирсэн монголч эрдэмтэн Оливер Корф сэтгэгдлээ хуваалцаж байсан. Таны тээж ирсэн зорилго биелэх магадлал хэдэн хувьтай байна?

-Хэдийгээр Өвөрмонголоос ирсэн, монгол гарал угсаатай эрдэмтэн гэлээ ч би Хятад улсын төлөөлөгч. Хятадын эрдэмтэн судлаач. Дэлхий ертөнц цаг хугацаатай уралдан хөгжиж байна. Ялангуяа, цахим ертөнц. Ийм цаг үед монгол хэл соёлыг хэрхэн яаж үр хойчдоо өвлүүлэн үлдээх вэ, даяаршиж буй дэлхий ертөнцөд яаж авч явах вэ, дэлхий нийтийн хүртээл болгох вэ гэх тухайд Монгол Улсыг сонирхон судалдаг эрдэмтэн судлаачид төдийгүй дэлхий даяар тархан суурьшсан монгол хүн бүр юу хийх ёстой талаар дуугарч, байр сууриа илэрхийлэн үзэл бодлоо нэгтгэх нь дамжиггүй Тэр утгаар нь Монгол Улс энэ удаагийн их хурлынхаа чиглэлийг “Монгол Улс ба тогтвортой хөгжил” хэмээн тодорхойлсон буй за. Салбар хуралдаануудын онцлог ч үүн рүү чиглэж байгаа бололтой. Үнэндээ аливаа улсын хөгжил тогтвортой байхын эх үндэс нь эх хэл, соёлын алтан цулбуурыг хэр чанга атгахаас



Гэрэл зургийг Г.АРИУУЖИН

...Дашрамд сонирхуулахад, өдөр тутмын бүхий л сониныг цахимжуулж, сан бүрдүүлсэн. Одоо 1921 оноос хойших хуулийг цахимжуулах төсөл хэрэгжиж буй. “Халх журам” –аас авахуулаад Чингэс хааны үеийн хуулийн эхийг ч бэлдэх болно...

С.НАСАН-УРТ:

Хэл, соёлынхоо алтан цулбуурыг чанга атгасан улс тогтвортой хөгждөг

талархаад ханашгүй сууна. Үнэн хэрэгтээ надад болон миний найз нөхдөд ийм сайхан боломжийг хэн олгов гэвэл Монголын төр. Монгол Улсын Ерөнхийлөгч энэхүү их хурлыг өөрийн ивээл дор зохион байгуулж, монголч эрдэмтдийн дуу хоолой, байр суурийг сонсоно гэдэг ухаантай хүний шинж шүү. Ерөнхийлөгчийн Тамгын газар болон холбогдох байгууллагууд, манай Хэл шинжлэлийн хүрээлэнгийнхэн маш сайн зохион байгуулж байгаа юм байна. Энд би өөрийн багштайгаа хүрэлцэн ирсэн. Багш маань цаг гаруйн өмнө Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржоос төрийн дээд шагнал болох “Алтан гадас” одонг хүртлээ. Багш маань энэ жил 86 хүрч буй. Энэ мэтчилэн баярт мөч давхцсан олон сайхан үйл явдал давхцсан үйл явдлын гэрч болоод зогсч байна, ах нь. Нөгөөтэйгүүр, монголч эрдэмтэд маань өнгөрсөн хугацаанд өөр өөрийн ажилладаг салбартаа их зүйлийг хийжээ. Манай сургуулийн болоод Өвөрмонголд аж төрж буй монголч эрдэмтдийн тухайд ч судалгаа, шинжилгээний

шалтгаалдаг. Миний тухайд монгол хэлийг компьютерт оруулах төсөл дээр өнгөрсөн зууны 80-аад оноос ажиллаж байна. Ингэж ажиллахдаа би технологийн дэвшлийг ашиглаад монгол хэл соёлоо дэлхий нийтийн хүртээл болгох боломжийг монголчууд алдах учиргүй хэмээн санааширч явдаг даа. Их хуралд илтгэл тавьж буй эрдэмтдийн байр суурь, чиг хандлага, хүсэл мөрөөдөл нь ч надтай ижил байгаа нь анзаарагдлаа. Энэ их сайн хэрэг.

-Би таныг саналаа. Та их тайлбар толийг бүтээлцсэн гадны цөөн эрдэмтдийн нэг шүү дээ.

-Баярлалаа. Тийм ээ, 2010 онд Шинжлэх ухааны академи Хэл зохиолын хүрээлэн хамтран хэрэгжүүлсэн “Их тайлбар толь” төсөл дээр ажиллаж, тэрхүү толь бичгийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүлээлгэж өгөх үеэр байлцсан.

-Монгол хэл, соёл маань цагийн салхинд “элэгдэж” өнөө үетэй золгохдоо олон талаар гээгдсэн байдаг. Харин өвөрмонголчуудыг хэл, соёлоо хамгийн сайн манаж

ирсэн ард түмэн гэгцгээдэг. Хоёр орны харилцаа сайжирсан эхний жилүүдэд бид та бүхний хэлийг сайн ойлгодоггүй байсан. Харин эдүгээ бид та нарын хэл аялгуугаар ярих бус та бүхэн бидэнд уусч орчин цагийн үгийг өдөр тутамдаа ашиглаад зогсохгүй бидний аялгаар ярьж байгаа. Энэ эмгэнэл үү, эсвэл дэвшил үү?

-Монголчууд өвөрмонголчуудыг өвөг дээдсийнхээ өв соёл, ёс заншлыг авч үлдэж чадсан хэмээн дүгнэдэг юм. Үнэндээ бас тийм биш. Өвөрмонголчууд цаг хугацааны эрхшээлд автан маш олон үнэт өв соёлоо алдсан шүү дээ. Монголчууд харин биднийг бодвол монгол хэл соёлоо биднээс илүү авч явж чадаж байгаа. Жишээ нь, мал маллах монгол ухаан байна. Бэлчээр ус, сүү, цагаан идээгээ боловсруулах гээд л. Өнөөдөр манай нутагт таван хошуу малаа нэрлээд яс үеийг нь зөв нэрлэж тоолох хүүхэд тун цөөн. Харин Ар Монголын хөдөөд аж төрж буй малчны хүүхэд бүр үүнийг мэднэ, чадна. Бүх зүйл сайн муу хоёр талтай шүү дээ. Нөгөөтэйгүүр, БНХАУ-ын

Засгийн газрын дэмжлэгтэйгээр өв соёлыг сэргээн хөгжүүлэх олон арга хэмжээг авч буйг би хэлэхийг хүсч байна.

-Өв соёлыг сэргээн хөгжүүлэх тухайд таны оруулж буй хувь нэмэр?

-Би XIII зуунаас хойших үеийн хөшөө дурсгал, бичгийн өв соёлыг цахимжуулах эх бэлтгэлийн ажлыг хариуцан ажилладаг. Үүний зэрэгцээ монгол хэл, соёлоор магистр, докторын зэрэг гориж буй оюутнуудад хичээл заадаг. Одоогийн байдлаар, миний шавь нараас тав нь доктор болсон. Мөн монгол хэлний цахимын сан бүрдүүлэлтийг санаачилсан. Эдүгээ төсөл хэрэгжиж буй. Шавь нарын гурав нь сан бүрдүүлэхээсгийг хариуцан ажиллаж байгаа. Дашрамд сонирхуулахад, өдөр тутмын бүхий л сониныг цахимжуулж, сан бүрдүүлсэн. Одоо 1921 оноос хойших хуулийг цахимжуулах төсөл хэрэгжиж буй. “Халх журам” –аас авахуулаад Чингэс хааны үеийн хуулийн эхийг ч бэлдэх болно. Энэ бүх хөдөлмөр зүтгэлийг минь Монголын төр

өндрөөр үнэлж, Соёлын тэргүүний ажилтан цол тэмдэг, “Найрамдал” одонгоор шагнасан.

-Та ямархан хувь тохиолоор монгол хэл, өв соёлтой холбогдов?

-Би бол ядуу, тарчиг малчин өвгөн, эмгэн хоёрын голомтод мэндэлсэн хүний орь ганц хүү. Хэдийгээр миний эцэг эх хоёр бичиг үсэг тайлагдаагүй хүмүүс байсан ч хүү намайгаа идэхээ шингэлж, дээлээ нимгэлж байж боловсрол эзэмшүүлсэн буянтай буурлууд. Би дөнгөж таван настайдаа хөршөөрөө үсэг заалгаж, бичиг үсэг тайлагдсан. Дараа нь хошууны сургуульд суусан. Манай амьдрал маш тарчиг. Аргал хомоол зарж гэмээнэ сургуульд сурах зардлынхаа мөнгийг олдог байлаа. Дээд сургуульд орсны хойно сайн багш нартай учирсан, би азтай хүн. Тэд маань л намайг хүний зэрэгтэй авч явсаар өнөөдөртэй золгуулсан ачтанууд. Бас нэг аз тохиосон зүйл гэвэл би Хятадын соёлын хувьсгалын дараа дээд сургуульд элссэн анхны оюутнуудын нэг.



ТАЛ НУТГИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЭЛ



MMINFO АПП
Тал нутгийн өдөр тутмын мэдээ мэдээлэл таны гарт...

TATAХ PLAY STORE | TATAХ APP STORE



ОНЦЛОХ ХУУДАС

Сенсаацийн эргэн тойронг

СЭТГЭЛ ГОНСОЙЛГОСОН ТОМИЛГОО ҮРГЭЛЖИЛСЭЭР...

2016 оны УИХ-ын сонгуулиар

МАН төрийн албыг төрлийн алба болгохгүй, дарга нарын хамаатан садан төрд томоохон алба хашихгүй, түүгээр ч барахгүй салбарынхаа жаргал зовлонг сайн мэддэг, давхар дээлгүй сайд нартай болно хэмээн амлаж байсан нь саяхан. Бүр сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргад мэргэжлийн хүмүүсийг томилж төрөө хямралаас гаргана гэж амлаж байсан тэдний үг үйлдэл бүр нь зөрж байгааг өнгөрсөн хугацаанд хийсэн сэтгэл гонсойлгосон томилгоонуудаас харж болох юм. Тиймээс энэ удаагийн "Онцлох хуудас" буландаа сайд болон дэд сайд нарын томилгоо болоод үнэ ханш нь өсөдөг буй Төрийн нарийн бичгийн даргын томилгооны талаар хөндлөө.

2012 ОНООС ХОЙШ АЖИЛД ОРСОН ХҮМҮҮСИЙГ СУДЛАХ ҮҮРЭГ ӨГЧЭЭ


Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Су.Батболд 2012 оноос хойш нийслэлийн харьяа төрийн байгууллагуудад ажиллаж байгаа албан хаагчдыг нэг бүрчлэн судалж, аттестатчилж, дүгнэлт гаргахыг үүрэгдсэн байх юм. Энэ нь төрийн албан хаагчдыг чадавхижуулах хэмээн нэрийн дор явагдаж байгаа халаа сэлгээ хийх арга гэнэ. Яг үнэндээ 2012 оноос хойш төрийн албанд ажиллаж эхэлсэн хүмүүсийг ийн судлах нь олноор нь хоморголон халах ажиллагааны эхлэл болж магадгүй гэдгийг эх сурвалжууд мэдээлж байна. Үнэний ортой л байх. АН-ын үед хотын дарга зургаан орлогчтой байна, олон байна хэмээн шүүмжилж байсан хэр нь одоо өөрсдөө "зургаахан" болгосон хэмээн хүмүүс шоолж байна. Дөрвөн орлогч, хоёр нь төслийн удирдагч гэсэн.

УЯАЧ НАР ШУРГАЛСАН ЗАСГИЙН ГАЗАР

МАН сонгуулиар үнэмлэхүй олонхи болсныхоо хүчээр ёстой л нэг дураараа дургиж, дунд чөмгөөрөө жиргэж байна гэхэд хилсдэхгүй. Ингэж хэлэх болсны учир нь тэд амлалтаасаа ухарч, ард түмний сэтгэлийг гонсойлгосон томилгоог эхнээс нь хийх болов. Сайд нараар эхэлсэн томилгоонд ард түмэн сэтгэл дундуур, бүр хамарсаж байгаагаа илэрхийлж, цахим ертөнцөд шуугиан дэгдэв. Үүний хүчинд зарим нэг нэр дэвшигчийг буцаасан. Үнэндээ "мэргэжлийн" гэх тодотголтой Засгийн газарт байгаа оносон томилгоо тунчиг цөөхөн байгаад УИХ-ын гишүүд ч өөрсдөө сэтгэл дундуур байгаа нь харгадсан. Наад захын жишээ дурьдахад л одоогийн Засгийн газарт уяач, уяачдын холбооноос хоёр ч байгаа нь иргэдээ төдийгүй, намынхныхаа уурыг бараад буй. Тодруулбал, Монголын морин спорт уяачдын холбооны ерөнхий нарийн бичгийн дарга, биенийн тамирын багш П.Сэргэлэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын сэнтийд зарласан бол Барилга, хот байгуулалтын дэд сайдаар Морин спорт, уяачдын холбооны тэргүүн дэд ерөнхийлөгч Ш.Лхамсүрэн томилгогдсоныг одоо ч хүмүүс шогшрон ярьсаар. Үүнийг УИХ-ын дарга М.Энхболд энэ холбооны Ерөнхийлөгч болохоор ийнхүү өөрийн хүмүүсээ "шагнасан" бололтой гэж ойлгохоос өөр яалтай билээ. Түүнийг томилгоо дээр "азаргалж" байгааг намынхан нь одоохондоо дотроо шивнэлдэн байгаа.

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ НЭРИЙН ЦААНА...

МАН өнгөрсөн хугацаанд нэг иймэрхүү л томилгоо хийж, олны амны бай боллоо. Тиймээс энэ үйлдлээ ухаарсан уу, ямартай ч яамны чухал хүн болох Төрийн нарийн бичгийн даргад нэр дэвшигчдийн дунд сонгон шалгаруулалт явуулахаар болсон байх юм. Үнэндээ ухаарсан хэрэг бус уг албан тушаалын "үнэ ханш"-ийг өсгөх гэсэн арга хэмээн хэвлэлүүд шүүмжилж байна. Угтаа бол сонгон шалгаруулалт нэрийн ард МАН-ынхан аль хэдийнэ Төрийн нарийн бичгийн даргын сунгаанд өрсөлдөөд эхэлчихсэн шүү дээ. Ийм л томилгоо үргэлжилж, иргэд харж байгааг ойлгох болов уу.



СЭТГЭЛД ХҮРЭХ ДЭД САЙД ХЭД БАЙГАА БОЛ...

Салбараа мэддэг, жаргал зовлонг нь ойлгодог сайд, дэд сайд нарыг томилно гэж амаа цангатай ярьснаа Ардын намынхан умартсаар. Үнэндээ одоо томилгоодод буй дэд сайд нараас салбараа мэддэг, сэтгэлд хүрэх нь гарын таван хуруунд багтахаар ажээ. Тоочоод, тодруулаад хэлбэл төрийн албанд 30 жил ажиллаж байгаа, 2008-2012 оны хооронд ХХААХУ-н дэд сайдаар ажиллаж байсан туршлагатай ёстой л өнөөх салбараа мэддэг дэд сайд нь Ж.Сауле байх юм. Мөн 2008 оноос Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдаар томилгогдон ажиллаж байсан УИХ-ын гишүүн асан Ё.Отгонбаярыг нэрлэж болж байна. Үүн дээр нэмээд нам төрийн ажлын туршлагатай, залуу хэрнээ боловсрол, мэдлэгтэй Т.Гантулгыг хэлж болох юм. Үнэндээ дэд сайдуудаас өөр нэрлэх хүн энд алга. Бусад нь жинхэнэ "бор халзан хонь", фракцийн тохироогоор орж ирсэн нөхөд.

БОЛОВСРОЛЫН "БОЛОВСРООГУЙ" САЙДЫГ ЯАЛТАЙ

Монгол Улсын хамгийн чухал салбарын нэг бол яах аргагүй боловсролын салбар. Хүн бүхэн бага балчирасаа эрдэм номд шамдаж, амьдралд хөл тавьдаг гэдэгтэй маргах хүн гарахгүй. Тэгвэл маш чухал энэ салбарт хамгийн муу томилгоо хийгдсэнд харамсч буй хүн олон байна. Учрыг тунгаавал, Барилгын инженер, эдийн засагч мэргэжилтэй хүн боловсролын салбарыг толгойлох болсон нь энэ салбар цаашдаа хөгжих эсэх асуудлыг хөсөр хаясан хэрэг хэмээн үзэх хүн ч гарч байна. Харин тус яамны дэд сайдаар өмнө нь боловсролын салбарыг толгойлж байсан Ё.Отгонбаяр томилгогдсон нь олны анхаарлыг нэлээд татаж байна. Үнэндээ МАН "мэргэжлийн" Засгийн газар байгуулах ухаантай байсан юм бол сайдын албыг хашиж байсан туршлагатай хүнээ сайд болгох ёстой байсан гэдгийг ч учир мэдэх хүмүүс хэлж байна. Бас болоогүй боловсрол, соёл, шинжлэх ухаан дээр Эрүүл мэндийн яамнаас спортыг салгаад нэмчихсэн болохоор сайд нь жижигдэж, салбар нь томдсон гээд хэлчихэд хатуудахгүй биз ээ.

САЙДААСАА ЗАНГАРАГТАЙ ДЭД САЙД БАЙНА ШҮҮ ДЭЭ

Сэтгэл гонсойлгосон бас нэг томилгоо Эрчим хүчний яаманд явагдсан байх юм. Тодруулбал, Эрчим хүчний сайдаар томилгогдсон П.Ганхүү байна. Уг нь тэр их сургуулиа төгсөөд энэ салбарын мэргэжилтнээс ажлын гараагаа эхэлж, салбарын яаманд хэлтсийн дарга, газрын даргаар ажилласан байсан нэгэн гэгдэх боловч албан тушаалын зангараг, буурь суурнар нэг л тохирохгүй гэдгийг олоод харчихжээ, зарим нь. Харин азаар тус яамны дэд сайдаар төр засгийн ажлын туршлагатай Т.Гантулга томилгогдсон нь яамай даа. Тэрбээр өмнө нь Төрийн нарийн бичгийн албыг зургаан жил хашсан, намын нарийн бичгийн даргаар ч чамгүй хугацаанд ажилласан гээд П.Ганхүүг бодвол ажил шүүрээд авахад зангаргаараа хийчих болов уу. Тэгэхээр МАН-ынхан үнэндээ боловсролтой, мэдлэгтэй залуусаа дэмжиж, төрийн албыг төрлийнх болгохгүй гэсэн амлалтаасаа ухарчихаад байгаагаа одоо хэр нь харахгүй байгаа бололтой.

Сэтгүүлчийн өнцөг

ЯЛАГДЛЫН НҮХЭЭ УХАЖ БАЙХ ВИЙ

Э.ТУУЛ

"Мэргэжлийн" Засгийн газар байгуулж, эдийн засгийн хямралаас гаргаж, иргэдээ сайхан амьдруулна гэсэн амлалт өгч гарч ирсэн МАН-ынхан Засгийн газраа бүрдүүлэх гэж ёстой л хөгөө хөлдөө чирж байна даа. Ялсан намын дарга нь Ерөнхий сайдын албанаас зугтаж, алх тогшихыг илүүд үзэн ажлаа Ж.Эрдэнэбатад үрүүлчихсэн. Нэгэнт хамаг

асуудлыг үүрэхээр болсон Ерөнхий сайд хуулийн хугацаандаа амжиж танхимаа бүрдүүлэх гэж их юм болов. Эхнээсээ л сайдад яригдсан хүмүүс нь бүдэрч, ашиг сонирхлын зөрчилтэй нь тогтоогдож, ар араасаа цуварсаар нэг юм бүрдсэн боллоо. Тэгэхдээ энэ томилгоог албан тушаалын "бялуу хуваалт", бүлэглэлүүдийн тохироо гэж хэн хүнгүй харж байна. Нам дотроо бол ганц хүний тулгалт хэмээн дургүйцэж буй. Одоо яамдын

Төрийн нарийн бичгийн дарга нарыг томилж томоохон хариуцлагатай ажил үргэлжилж буй. Төрийн нарийн бичгийн дарга гэдэг тус яамныхаа хамаг л хөрөнгө мөнгийг захиран зарцуулах эрх мэдэлтэй хүн байдаг. Тэгвэл уг томилгоотой холбоотой олон мэдээлэл гарч эхэлсэн нь хүмүүсийн анхаарлыг татаж байна. Үнэндээ Төрийн нарийн бичгийн дарга нарт намаас "зүтгүүлж" буй хүмүүсийн нэр урьдчилсан

байдлаар олонд ил болсон. Төрийн нарийн бичгийн даргад нэр дэвших магадлалтай хүмүүсийн талаар янз бүрийн мэдээлэл цахим хуудаснаа хөвөрч байна. Арга ч үгүй биз. Сонгуульд ялалт байгуулахдаа "Мэргэжлийн" Засгийн газар байгуулна гэж амласан МАН-ынхан сайд нар болон дэд сайдуудын томилгоог хийхдээ олон "оноо" алдсан. Тэр ч утгаараа иргэд одоо тэднийг томилгоо бүр дээр өөнтөглөж, бас үг, үйлдэл бүрийг нь

няхуур хянаж байгаа. Төрийн албыг жинхэнэ утгаар нь төрлийн алба болгож, цаашлаад шагнал, дараагийн сонгуулийн мөнгөө босгох хэрэгсэл болгож байгааг ч хэн хүнгүй ярьж байна. Цаашдаа төрийн албан хаагчдыг хоморголон халж, төрийн албыг "толбөртэй болгох" ажлаа хийсээр байх юм бол ойрын хоёр сонгуульд ялагдах "нүх"-ээ ухааж байна хэмээн ойлгох хэрэгтэй дээ.

Тал нутгийн цахим мэдээлэл

ДЭЛХИЙ



Согтуугаар МАШИН ЖОЛООДСОН САЙД ОГЛОРЧЭЭ

Боснигийн цагаачдаас гаралтай Шведийн түүхэн дэх хамгийн залуу Засгийн газрын гишүүн 29 настай Айда Хадзалик согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож саатуулагдсан гэх шалтгаанаар албан тушаалаасаа огцорчээ. Бүсгүй Дунд болон насанд хүрэгчдийн боловсролын сайдын албыг хашиж байсан юм. Тэрбээр Шведийн нийслэл Стокгольм хотын Засгийн газрын ордонд сэтгүүлчдэд мэдээлэл хийх үедээ Малмогийн цагдаа нарт саатуулагдсан талаараа ярьсан байна. Түүний цусан дахь

алкохолын хэмжээ 0.2 грамм байжээ. Айда Хадзалик "Миний амьдралдаа гаргасан хамгийн том алдаа энэ байлаа. Би хариуцлагаа хүлээж, сайдын албан тушаалаасаа огцорч байна" гэж мэдэгдсэн байна. Мөн "Маш олон хүмүүс миний гаргасан үйлдэлд уурсаж байна. Би ч гэсэн өөртөө уур хүрч, болсон явдалд гүнээ харамсч байна" гэжээ. Түүний хувьд Нийгмийн Ардчилал намын ирээдүйтэй улстөрчдийн эгнээнд багтаж байв. Боснигийн цагаач гэр бүлээс гаралтай бөгөөд таван настайгаасаа хойш эцэг эхийнхээ хамт Швейцарь суурьшжээ. Улмаар ахлах сургуульд байхдаа Нийгмийн ардчилал намын залуучуудын хөдөлгөөнд гишүүнээс элсч, 23 насандаа хотын захиргаанд гишүүнээр сонгогдож байсан аж. 2014 онд 27-хон насандаа Шведийн хамгийн залуу Засгийн газрын гишүүн болж байв.

АНУ, Туркийн ХАРИЛЦАА ХУРЦАДСААР БАЙНА

Б.ДАВАА

Туркид цэргийн эргэлт хийхийг завдсанаас хойш яг нэг сарын хугацааг үдээд байна. Туркийн Засгийн газрын хувьд цэргийн эргэлтийг лалын хэт даврагч бүлэглэлийн удирдагч, шашин судлаач нэрт сэтгэгч Гюлен Фетхуллахыг хөшигний араас удирдсан хэмээн хардаг, түүний орогнож буй АНУ-аас түүнийг өөрийн улсын талд шилжүүлэн өгөхийг шаардсан. Гэвч АНУ-ын тал одоогийн байдлаар эл асуудалд тодорхой хариулт өгөхөөс татгалзах болсноор хоёр улсын харилцаа улам бүр муудсаар байгаа юм. Хоёр улсын найрамдалт харилцаанд нөлөөлөхөд хүргэсэн дээрх хэргийг Туркийн цэргийн зарим албан тушаалтнууд өдүүлж, төрийн эргэлт хийхийг завдсан ч хотын иргэдийн эсэргүүцэлтэй тулгарсны улмаас хагас өдрийн дараа бүтэлгүйтлээр төгссөн. Энэ үеэр нийтдээ 240 хүн амь үрэгдсэн бөгөөд тэдний дунд хотын гэм зэмгүй иргэд олноороо багтаж байжээ. Тэгвэл энэ явдлаас яг нэг сарын хугацаа өнгөрч буй энэ үед Туркийн хамгийн том хот Истанбулын төмөр замын буудалд хохирогчдын хөрөг зураг өлгөгдөж, цэргийн эргэлтээ ардчиллаа хамгаалан үлдсэн баатарлаг үйлсийн бэлгэдэл болж байна. Цэргийн эргэлттэй холбоотойгоор эдүгээг хүртэл 20 гаруй мянган цэргийн алба хаагчид баривчлагдан саатуулагдаж, харин гол удирдагчийг нь Гюлен хэмээн хардаг буй

Туркийн эрх мэдэлтнүүд Нэгдсэн улсад удаа дараа шаардлага хүргүүлсээр байгаа тухай албаны эх сурвалж мэдээлжээ.

Гэвч шашин судлаач Гюлен цэргийн эргэлт дэх өөрийн оролцоог үгүйсгэж байгаа бөгөөд АНУ-ын Засгийн газар Туркийн талын нотлох баримтыг хянан үзсэн ч эдүгээг хүртэл хариу өгөөгүй байна. Ийм нөхцөл байдалд Нэгдсэн улсын дэд Ерөнхийлөгч Йосеп Байден энэ сарын 24-ний өдөр Туркид албан ёсны айлчлал хийхээр болсон. Түүний айлчлалын үеэр Гюленг Туркийн талд шилжүүлэх эсэх талаархи асуудал яригдана гэж олон улсын шинжээчид таамаглаж байгаа юм. Гэвч хоёулаа Умард Атлантын цэргийн эвсэлд харьяалагдах холбоотон улсууд лалын хэт даврагч бүлэглэлийн эсрэг тэмцэлд харилцан зөрүүтэй бодлогыг баримталж буй нь хоёр улсын харилцаа хурцдахад нөлөөлсөөр байна.

Туркийн Засгийн газар Гюлен шашны бүлэглэл олон жилийн турш цэрэг, төрийн байгууллага, боловсролын байгууллагад шургалж, улсын бүх эрх мэдлийг гартаа авахаар зэхэж байсан хэмээн буруутгаж байгаа. Улмаар түүний ойрын хүмүүсийг цэвэрлэхийн тулд өнгөрсөн сард онц байдал тогтоож, 80 гаруй мянган төрийн албан хаагчийг ажлаас нь халж, их сургууль гэх мэт боловсролын байгууллагаас гадна телевиз, сонин сэтгүүл зэрэг хэвлэл мэдээллийн 130 гаруй байгууллагын үйл

ажиллагааг зогсоожээ. Ямартай ч, Гюлентай холбоотойгоор хоёр улсын харилцаа муудаж байгаа ч, АНУ-ын тал ямар нэг тоймтой хариу өгөхгүй байгаа зарим ажиглагчид хэд хэдэн шалтгаантай холбон тайлбарлаж байгаа юм.

Нэгдүгээрт, хууль эрхзүйн орчин. Төрийн нарийн бичгийн дарга Жон Керригийн хэлж буйгаар тухайн сэжигтнийг гэмт хэрэг үйлдсэн гэдэг нь баттай нотлох баримтаар тогтоогдоогүй байхад баривчлан хорихыг тус улсын хуульдаа хориглосон байдаг аж. Гэхдээ Керри Гюлен гэм буруутай гэж үзэх нотлох баримтыг Туркийн тал үзүүлсний дараа ямар нэг мэдэгдэл хийгээгүй байгаа юм. Хоёрдахь нь хүмүүнлэгийн үйл ажиллагаатай холбоотой. Улс төрийн шахалт хавчлагаас үүдэн орогнол хүсч, тухайн улсад байрлаж буй иргэнийг эх оронд нь шилжүүлэх нь хүмүүнлэгийн үйл ажиллагаанд харшлантай гэж үзэж буй гэнэ. Харин гурав дахь шалтгааны тухайд шашинтай холбосон бол дөрөв дэх шалтгааныг улстөрийн бодлоготой холбон тайлбарласан байна. Эрдоганы Засгийн газар зургадугаар сарын сүүлчээ эхлэн ОХУ-ын Ерөнхийлөгчтэй харилцаагаа сайжруулж, Лалын улс бүлэглэлийн эсрэг тэмцлээс АНУ тэргүүтэй барууны орнуудыг шахах болсон нь нөлөөлсөн гэж үзэх үндэслэлтэй гэнэ. Ямартай ч, энэ сарын 24-нд болох АНУ-ын дэд Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр дээрх асуудал хөндөгдөж магадгүй байна.

Хулгайлагдсан охидын шинэ бичлэг цацагдлаа

Баруун Африкийн Нигерийн хойд этгээдийн тосгоноос 200 гаруй охид лалын хэт даврагч "Боко Харам" бүлэглэлд хулгайлагдсан хэрэг 2014 оны дөрөвдүгээр сард гарч байв. Тухайн үед гэмт хэрэгтнүүд охидын бичлэгийг цацаж байсан ч, эцэстээ охид амьд мэнд байгаа эсэх нь тодорхойгүй

болж эхэлсэн. Тэгвэл Боко Харам бүлэглэл охидын талаархи шинэ бичлэгийг олон нийтэд дэлгэлээ.

Тус бүлэглэл "Охид одоо ч бидний хяналтад байна" гэж хэлээд Нигерийн Засгийн газарт хандан шоронд хоригдож буй Боко Харам бүлэглэлийн дайчдыг суллахыг шаардсан байна. Бичлэгт нүүрээ халхалсан

баг өмссөн Боко Харамын дайчид болон 50 гаруй охидын дүрс бичигдсэн байна. Охид ядарсан царайтай харагдах бөгөөд нулимс унагаж байжээ. Үүнээс гадна бэлгийн боолчлолд өртсөний тод жишээ гэлтэй өөрөө хүүхэд атлаа жаахан хүүхэд гартаа тэвэрсэн охид ч камерын дуранд өртсөн байна.

Нью-Йоркт буун дуу гарчээ



АНУ-ын Нью-Йорк хотын Жон Кеннедийн нэрэмжит олон улсын нисэх онгоцны буудалд хэд хэдэн удаа буун дуу гарсны улмаас хүмүүсийг нүүлгэн шилжүүлсэн тухай зарим барууны сайтуд мэдээлжээ. Эх сурвалжийн мэдээлснээр, орон нутгийн цагаар ням гарагийн орой тус нисэх онгоцны буудлын нэг болон хоёрдугаар терминалд гурван удаа буун дуу гарсан байна. Цагдаа нар хэргийн газраас хүмүүсийг нүүлгэн шилжүүлж, сэжигтнийг хайж байна. Хүний амь эрсэдсэн гэх мэдээлэл байхгүй байна. Энэ хэргийн улмаас тус нисэх онгоцны буудал бүх нислэгээ цуцалжээ. "Нисэх онгоцны буудлын үйл ажиллагааг бүрэн зогсоогоод байна. Ирж буй бүх нисэх онгоцныг өөр нисэх буудлуудад газардуулж байна" гэж цагдаа нар мэдэгдэв.

100 гаруй хүн үерт өртөж амиа алдлаа

Дэлхийн дулааралтай холбоотойгоор Африкийн бүс нутаг байгалийн онц ноцтой үзэгдэлд нэрвэгдэх болжээ. Улмаар Суданд энэ жилийн зургадугаар сараас эхлэн ширүүн бороо орсны улмаас үер бууж, хамгийн сүүлд авсан мэдээллээр 100 гаруй хүн амиа алдсан байна. НҮБ-ын мэдээлснээр Суданд зургадугаар сараас эхлэн ширүүн бороо үе үе орж, тус улсын зүүн хэсгийн бүс нутгийн томоохон хэмжээний талбай усанд автаж, 120 гаруй мянган хүн хохирол амсч, байшин барилга нурж, хүний амь үрэгджээ. Хамгийн сүүлийн үеийн мэдээллээр 20 мянга гаруй байшин барилга нурж, оршин суугчид нь гадаа майханд амьдарч буй бөгөөд нийслэл хот болон хөдөө орон нутгийг холбосон зам ихээр гэмтсэний улмаас хоол тэжээл, эм тарианы хомсдол үүсчээ. Түүнчлэн, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх бага насны хүүхдийн тоо тасралтгүй нэмэгдсээр байгаа гэнэ.

НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРАНД УРЬЖ БАЙНА

Залуус та бүхнийг Дэлхийд алдартай Apple, Bose, Dell, Samsung, HP, Bosch, Sony, Epson, Sharp, Acti, Haier, Orient, Casio, Schneider, LG, Moshi, Yamaha зэрэг брэндүүдийн мэдээллийн технологийн чиглэлийн бараа бүтээгдэхүүн болон цахилгаан барааг албан ёсны эрхтэйгээр борлуулагч "Саммит Компьютер Технологи"-компанид БАЙГУУЛЛАГА ХАРИУЦСАН МЕНЕЖЕР-ийн ажилд урьж байна.

Манай компанид ажилд орсноор та бүхэн мэдээллийн технологийн чиглэлээр өргөн мэдлэгтэй болохын зэрэгцээ олон төрлийн сургалт, хөгжлийн хөтөлбөрт хамрагдан өөрийгөө хөгжүүлэх боломжтой юм.

Тавигдах шаардлага:

- Гадаадын Их дээд сургуулиудад бизнесийн удирдлага, эдийн засаг, гадаад харилцаа, олон улсын худалдааны чиглэлээр бакалавр болон түүнээс дээш зэрэгтэйгээр төгссөн
- Ажлын 2-оос доошгүй жилийн туршлагатай
- Англи хэлний бичгийн болон ярианы өндөр чадвартай 1-ээс дээш гадаад хэлний мэдлэгтэй бол давуу тал болно
- Харилцааны өндөр чадвартай болон технологийн талаар

- мэдлэгтэй бол давуу тал болно.
- Гэрээ хэлцэл байгуулах, албан бичиг баримт боловсруулах чадвартай
- Багаар болон бие даан ажиллах, хувийн зохион байгуулалт сайтай, хурдан шаламгай хөдөлгөөнтэй
- Илүү цагаар ажиллаж ачаалал даах чадвартай
- Идэвх санаачилгатай тогтвор суурьшилтай ажиллах

Бусад:

- Цалин-Тохиролцоно
- Төрөл-Бүтэн цагийн
- Түвшин - Ахлах мэргэжилтэн
- Салбар-Мэдээллийн технологи

Дээрх шаардлагыг ханган, ажилд орох сонирхолтой залуус дараах хаягаар өөрийнхөө товч анкет /CV /-г илгээнэ үү.



ТАНЫ ХЭРЭГЛЭЭНД ТӨГС НИЙЦНЭ...

Холбоо барих:
Имэйл: hr@summit.mn
Утас: 70073535

ЗАВСАРЛАГА

РИО-2016

Орчуулсан Б.ДАВААХҮҮ

“Дэлхийн хамгийн хурдан хүн”, “Шахилгаан Болт” гэх мэт нэрээр алдаршсан хөнгөн атлетикийн тамирчин Усэйн Болтын нэгэн ярилцлагыг “Оддын цаг” буланд аарчуулан хүргэж байна. Эдүгээ 29 настай тэрбээр хүн төрөлхтөний эв нэгдлийн бэлгэдэл болсон Риогийн Зуны олимпийн 100 метрийн зайн уралдаанд аваргалж, Олимпийн гурав дахь алтан медаль хүртээд байгаа юм. Түүнийг тэмцээн орохын өмнө ээж нь нэгэн хөвдөл өгсөн ярилцлагадаа Риогийн олимпийн дараа хүүгээ гэр бүлтэй болоосой гэж хүсч буйгаа ярьжээ. Ингээд “Дэлхийн хамгийн хурдан хүн”-ий ярилцлагыг уншигчиддаа сонирхуулья.

Усэйн Болт: БИ ХӨЛӨНДӨӨ ХАЙРТАЙ

...“Болт чиний хөл үнэхээр муухай юм” гэж хэлдэг л юм. Харин би тэр үед нь “Үнэн. Гэхдээ чиний хөл чамд хэр их мөнгө олж өгч чадах вэ” гэж асуудаг...

-Шуудхан асуучихья. Риогийн олимпод бид танаас ямар амжилтыг хүлээх вэ?

Гурваас дээш олимпийн алтан медальтай тамирчин. Өнгөрсөн жил би хэдэн сарын турш гэмтэлтэй байсан. Энэ мэт асуудал байсныг хэн ч мэдээгүй. Бээжингийн олимпоос алт авсан. Энэ жил ч гэсэн бэлтгэлээ сайн базаасан болохоор амжилт гаргаж чадна гэдэгтээ итгэлтэй байна. Магадгүй миний амьдралын хамгийн удаан жил болж өнгөрөх шиг боллоо. Ер нь

олимпийн жил их хурдан өнгөрдөг юм. Энэ жилийн олимпод түрүүлж, амжилтын амтыг мэдрэхийг хүсч байна. Алтан медаль, эсвэл бүтэлгүйтсэн ч бай би сэтгэлээр унахгүй. Удаан хугацааны дараа хүмүүс миний буруу биш байсан гэдгийг ойлгох учраас тэр. Зөвхөн өөртөө анхаарал хандуулах болно.

-Олимпийн медальтай үгээгүй ядуу, эсвэл медальгүй чинээлэг байхын аль нь илүү вэ?

-Ямар хэцүү асуулт вэ. Миний бодлоор амжилт, медаль илүү чухал. Хүүхэд байхад надад мөнгө байгаагүй. Гэхдээ түүнээс ч илүү чухал зүйлс намайг хүрээлж байсан. Тийм болохоор Олимпийн аварга болж, шаргуу хөдөлмөрийнхөө амт, ялалтыг мэдэрч чадаж л байвал ядуу амьдрал миний хувьд асуудал биш.

-Хэрвээ та хүүхэдтэй болбол таны ямар занг битгий өвлөөсэй гэж хүсдэг вэ?

-Залхуу занг. Дасгал сургуулилтаас бусад үед би маш залхуу. Заримдаа зурагт үзэж байхдаа дөрвөн инч хол байгаа зүйлд хүртэл хүрэхгүй

найзаараа авахуулдаг. Мөн орондоо орсон хойноо буцаж босохоос залхуурсандаа урд хаалгаа онгорхой унтсан тохиолдол ч бий.

-Биеийнхээ аль хэсэгт хамгийн хайртай вэ?

-Хөлөндөө хайртай. Хүмүүс харахад тийм ч сайхан биш л дээ. Зарим залуус “Болт чиний хөл үнэхээр муухай юм” гэж хэлдэг л юм. Харин би тэр үед нь “Үнэн. Гэхдээ чиний хөл чамд хэр их мөнгө олж өгч чадах вэ” гэж асуудаг.

-Та өөрийнхөө гоц авьяасын талаар хэзээ мэдсэн бэ?

-Би бүр хүүхэд байхаасаа л хурдан гүйдэг байсан. Сургуульд байхдаа олон ч уралдаанд түрүүлж байлаа. Гэхдээ Өсвөрийн хөнгөн атлетикийн Дэлхийн аварга болохдоо надад үүнээс ч илүү боломж, авьяас чадвар байгааг мэдэрсэн.

-Тэгэхээр төрөлхийн хурдан гэсэн үг байх нь э?

-Төрөлхийн авьяас чадвар заяасан болохоор би их азтай хүн. Гэхдээ одоогийн амжилтад хүрэхийн тулд шаргуу хөдөлмөрлөсөн. Дасгал сургуулилт хийсний хүчинд би

одоо 100 метрт 10-аас доош секундэд хурдаж чадна. Арга техникээ сайжруулж, фитнес төвд хүнд дасгал сургуулилтыг хийж, байнга бэлтгэлтэй байсны дүнд олимпоос медаль хүртэж чадаж байна.

-Хэн нэгэнтанд “хангалтгүй байна” гэж хэлж байсан удаа бий юу?

-Яг ч тэгж хэлж байгаагүй. Гэхдээ заримдаа хүмүүс намайг залхуу хойрго, шоучин гэх мэтээр ярихад нь жаахан бухимддаг.

-Өөр ямар төрлийн спортыг сонирхдог вэ?

-Би крикет болон хөлбөмбөг тоглодог. Хөлбөмбөг тоглож байхдаа би хамгаалагч, эсвэл төвийн тоглогчийн үүрэг гүйцэтгэдэг. Энэ хоёр спортоос магадгүй крикетдээ илүү сайн байх. Мэргэжлийнх байсан бол одоо илүү сайн крикетер байх байсан болов уу. Магадгүй хамгийн сайн тамирчин ч болж болох байсан гэж би боддог юм.

-Харин хамгийн муу спортын тухайд?

-400 метрээс дээшхи зайн уралдаан. Марафон бил үү. Надад ямар ч боломж байхгүй.

-Таны спортын шүтээн хэн байв?

-Ямайкийн ойрын зайн тамирчин Доналд Карриг шүтдэг. Би бас Манчестер Юнайтедийн шүтэн бишрэгч.

-Хэр сайн тогооч вэ?

-Өндөг шарж, омлет хийж чадна. Ер нь өглөөний цайгаа бол өөрөө бэлдчихнэ гэж ойлгоход болно.

-Медалиудаа хаана хадгалдаг вэ?

-Медалиудаа банкинд хадгалж байгаа. Тэднийг хаяж чаддаггүй юм. Нэг удаа Дэлхийн аваргын медалиудаа хаана хадгалснаа мартаад хэдэн сарын турш хайсны эцэст олж билээ. Гэтэл миний шүүгээнд байсан шүү.

-Юу хамгийн их уурыг тань хүргэдэг бол?

-Хүмүүс өглөө бүр 09:00 цагт манай хаалгыг нүддэг. Тэд намайг сонсдоггүй юм болов уу.

-Харин юунаас аз жаргалыг мэддэг вэ?

-Хоол, уснаас. Наргиа байсан шүү. Гэртээ телевизийнхээ урд, шлэй стэйшнтэйгээ, бас оройн хоол, найзуудтайгаа байх миний хувьд жаргал шүү дээ. Охидтой байхдаа ч гэсэн. Гэхдээ царайлаг охидтой.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр 21
Шөнө 12

Нөгөөдөр
Өдөр 20
Шөнө 10

Өдрийн зурхай

БИЛГИЙН ТООЛЛЫН 13
Намрын тэргүүн улаан бич сарын
Дөрвөн ногоон мэнгэтэй цагаан морь өдөр

Үс засуулбал:
Жаргал ирнэ.
Наран ургах, шингэх:
05.51-20.00



Аргын тооллын 8 сарын 16, Ангарга гараг. Билгийн тооллын 13, Элдэв тэнгэртэн одтой, цагаан морь өдөр. Өдрийн наран 5 цаг 51 минутад лондан, 20 цаг 02 минутад жааргана. Тухайн өдөр баф, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хяналгай хандаж, бие энхрийлүүштэй. Эл өдөр гэлтнийг шийтгэх, лусыг тахих, тангафагаа буцаахад сайн. Гэр бүрэх, хэрүүл тэтэй хийх, сэтгэлд сэтэй газар очих, хүүхэд хөлд оруулахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод баруун урагш төрөө гаравал зохистой. Үс шинээр үргээлэх буюу засуулбал жаргал ирнэ.

СОНИРХУУЛАХАД

Олимпийн медалийн тавцанд сүй тавив

Хүн төрөлхтөний эв нэгдлийн бэлгэдэл болсон Риогийн олимпод эх орноо төлөөлөн оролцохоор хүрэлцэн очсон Хятадын хоёр тамирчин амьдралдаа тохиох чухал мөчүүдийнхөө нэгийг олимпийн медалийн тавцанд өнгөрүүлжээ. Тодруулбал, гурван метрийн трамплины төрөлд мөнгөн медаль хүртсэн Хятадын тамирчин 25 настай Хе Зиг олимпийн мөнгө медалийн хамт, жижиг хайрцагтай сүйн бөгж дагалдан ирсэн байна. Түүнийг медальна аваад буух үед найз залуу Цин Кай нь өвдөг дээрээ сөхрөн сууж, жижиг улаан хайрцаг бүхий бөгжийг өмнөө барьж, гэрлэх санал тавьжээ. Олимпийн мөнгөн медалийг энгэртээ зүүсэн бүсгүй гэнэтийн гэрлэх саналд баймагдаж нулимс дуслуулан саналыг хүлээн авсан аж. Түүний найз залуу мөн усан спортын тамирчин, түүнтэй ижил төрлөөр хичээллэдэг бөгөөд олимпоос хүрэл медаль хүртсэн нэгэн билээ.

TENGIS
МУВИЯЛГА

Нэгэн залуу хайр дурлалынхаа төлөө өглөө бүр хийдэг дадал зуршил болсон гэнэтийнхээ бэлгийг хайртай охиндоо барьснаар киноны үйл явдал эхэлнэ. Үүнээс үүдэж өөр хайр дурлалтай учирна. Энэ хайр дурлалыг нь хоёр найз нь эсэргүүцэж киноны үйл явдлыг өрнүүлж асуудлыг улам хурцдуулна.



Засгийн газрын нууц агентлаг маш нууц ажиллагаа явуулахын тулд шоронд хоригдож байгаа онц ноцтой гэмт хэрэгтнүүдэд өршөөл үзүүлэхээр амлаж золиосны суман бүрдүүлнэ.

УДАХГҮЙ ТЭНГИСИЙН ДЭЛГЭЦНЭЭ



Гаргах уулцаж 2016.08.19



Гаргах уулцаж 2016.08.19



Гаргах уулцаж 2016.08.19



Гаргах уулцаж 2016.08.26



Гаргах уулцаж 2016.08.02